

³⁴ Джангар: Калмыцкий героический эпос / Сост., подг. текст., коммент. и словарь Н. Ц. Биткеева, Э.Б. Овалова; перевод с калм Н. Ц. Биткеева, Э.Б. Овалова и др.; АН СССР. Ин. мир. лит. Калм. НИИИФЭ. М.: Наука, Глав. ред. вост. лит. 1990.

³⁵ “Джангар”. Малодербетская версия” (сводный текст, перевод, вступительная статья, комментарии, словарь А. Ш. Кичикова) Элиста: КалмГУ, 1999. 272 с.

³⁶ Овалов Э. Б. Эпос “Джангар”: его региональные версии // Олонхо в контексте эпического наследия народов мира. Якутск, 2000. С. 13.

³⁷ Кудияров А. В. К вопросу о монгольских записях “Джангара” // Фольклор: Издание эпоса. М., 1977. С. 279-285. Овалов Э. Б. О монгольской версии “Джангара” (Записи и публикации) // Типологические и художественные особенности “Джангара”. Элиста, 1978. С. 7-14.

Үеийн баахан богдо ноен Жанрай хаан / зап. Б. Ринчен 1930г. // Asiatische Forschungen. Bd.II. Wiesbaden, 1963. S.1-32.

³⁹ Жангарын туульс / Предисл., коммент., сост. У. Загдсүрэн // Аман зохиол судлал. Улаанбаатар, 1968. – Т.VI. Вып. 15.

Жангар / Халимаг хэлнээс монгол хэлэнд буулгасан Т. Дүгэрсүрэн. Ред. Ц. Дамдинсүрэн. Улаанбаатар, 1963. 273 с.

⁴¹ Владимирцов Б. Я. Монголо-ойратский героический эпос. М.-Пг. 1923.

⁴² Козин С. А. Джангариада: Героическая поэма калмыков. М.; Л. 1940.

Е. Баярсайхан

Хоёр академийн хамтын бүтээл – «Монгол орос дэлгэрэнгүй их толь»

Шинэ мянганы, шинэ зууны эхний хоёр жилд дөрвөн боть Монгол орос дэлгэрэнгүй их толь (Большой академический монгольско-русский словарь) Москва хотноо хэвлэгдэн гарлаа.

Монгол орос дэлгэрэнгүй их толийн зохиогч, редакторын хамт олон энэхүү бүтээлээ Монгол улсын ШУА-ийн жинхэнэ гишүүн Амгаагийн Лувсандэндэв, Оросын ШУА-ийн сурвалжлагч гишүүн В.М. Солнцев нарын гэгээн дурсгалд зориулав. Чухамхүү энэ хоёр эрдэмтний үүсгэл санаачлагаар уул толийг зохиох бэлтгэл ажил, эрдэм шинжилгээний аргазүйг боловсруулах, толь зохиох ажлын хэсгийг байгуулах, улмаар толийн ажлын явц өрнөсөн билээ.

Монгол орос дэлгэрэнгүй их толийг зохиоход урьд хэвлэгдсэн хуучин шинэ янз бүрийн толь, нэр томъёоны толь, мэдээ,

цуврал бичгүүдийг ашигласан ба тухайлбал Орос зөвлөлтийн эрдэмтэдийн 1940-оод онд хамтран зохиосон монгол орос толийн машиндсан эх материал чухал хэрэглэгдэхүүн болсныг дурдая.

Энэ толинд А.В. Бурдуков, С.Д. Дылыков, академич С.А. Козин, Б.И. Панкратов, сурвалжлагч гишүүн Н.Н. Поппе, Г.Д. Санжеев, К.М. Черемисов нарын нэрт монголч эрдэмтэд зохиогчоор ажиллаж байв.

Эдүүгээ энэхүү гурван боть монгол орос толийн 5 мянга гаруй машиндсан хуудас бүхий 8 хавтас гар бичмэл Оросын ШУА-ийн Дорно дахины хүрээлэнгийн архивын дорно дахины судлалын гар бичмэлийн тасагт Р. I. Оп. 3, № 62 гэсэн дугаартай хадгалагдаж байна.

Нэрт эрдэмтэдийн зохиосон монгол орос толь нь хэдийгээр гар бичмэл болон үлдсэн боловч, сонгодог монгол бичгийн хэлээр хуучин бичиг зохиол уншихад хэзээ ч үнэ цэнээ алдахгүй, улмаар толь бичгийн чухал хэрэглэгдэхүүн, үнэт лавлах бичиг хэвээр байсаар байх болно.

Монгол үндэсний мэргэжилтэн нарын зохиосон анхны монгол орос толь 1957 онд Москва хотноо 22 мянган үгтэй хэвлэгдэн гарсанаас хойш даруй 50-иад жил өнгөрчээ. Энэхүү толь нь тухайн үеийн тользүйн шаардлагыг хангасан монгол хэлний ихэнх үгийг багтаасан маш сайн толь болсон бөгөөд өнөө хүртэл уншигч олны орчуулгын гол гарын авлага болсоор ирэв.

Үүний өмнө орос зөвлөлтийн эрдэмтдийн зохиосон их бага янз бүрийн монгол орос, орос монгол толь хэвлэгдэн гарсны тоймтой заримыг дурдвал, О. Ковалевскийн 1844-1849 онуудад Казань хотноо хэвлүүлсэн 3 боть Монгол орос франц толь, Ф.Г. Голстунскийн 1894-1898 онуудад Санкт-Петербург хотноо хэвлүүлсэн 3 боть монгол орос толь, К.М. Черемисов, Н.Г. Румянцев нарын 1937 онд Ленинградад хэвлүүлсэн Монгол орос толь, А. Ринчиний 1947 онд Москвад хэвлүүлсэн Монгол орос товч толь зэрэг олон толь болно. Мөн сүүлийн жилүүдэд зохиосон монгол орос толь, тухайлбал, Ц. Цэдэндамбын 1997 онд Улаанбаатар хотноо хэвлүүлсэн Монгол орос толь, Ю. Кручкины 2001 онд Москвад хэвлүүлсэн 60 мянган үгтэй Монгол орос толийг дурдаж болно.

Сүүлийн 50-иад жилийн дотор тользүйн онол практикийн хүрээнд томоохон өөрчлөлт орж, хоёр хэлний толь зохиох тэр тусмаа хэлний хоёр өөр системд хамрагдах монгол орос толь зохиох зарчим чанарын шинэ шатанд шилжиж, монгол орос толийг хэлний орчуулгын толиноос хэлэхүйн төвшинд хүргэх зорилт тавив.

1921 онд Монголд ялсан ардын хувьсгалаар боловсролын систем үүсч, шарын шашны төвд хэлний сургалтыг халж, хэвлэл мэдээл, радио телевиз үүсч, эртний монгол хэлний үгзүйн бүтцийг хадгалсан уйгаржин монгол бичгээс орос үсэгт үндэслэсэн шинэ бичиг авч хэрэглэсэн нь утга зохиолын хэлийг орчин цагийн ярианы хэлэнд ойртуулж, бичгийн хэлний хэлзүйн бүх төвшинд өөрчлөлт оруулж, зөвхөн бичдэг биш, мөн ярьдаг утга зохиолын хэлтэй болох, халх аялгуунд суурилан үүссэн монголын нэгдмэл хэлийг улам бататган дэлгэрүүлэх бололцоотой болов. Монгол хэлний үгсийн санд ихээхэн өөрчлөлт орж, шинэ үг хэллэгээр улам баяжин, үгийн үндсэн утга улам өргөжин дэлгэрэв.

Монгол утга зохиолын хэлний түүхэн хөгжлийн гуравдугаар шат буюу XVII зуунаас эдүүгээ хүртлэх үеийн үгсийн санг аль болохуйц бүрэн багтаасан монгол орос дэлгэрэнгүй их толь тухайлбал монгол орос орчуулгын томоохон толь ажил хэргийн үүднээс онцгой шаардлагатай болсон учир Монголын ШУА, Оросын Шинжлэх Ухааны Академийн хоёр талын хамтын ажиллагааны төлөвлөгөөний II 2/2 заалтад тусгалаа олсон билээ.

Монгол орос дэлгэрэнгүй их толь зохиох зарчмыг А. Лувсандэндэв, Г.Д. Санжеев нар 1972 онд боловсруулав. Хэлэлцэн тохирсон ёсоор монгол орос дэлгэрэнгүй их толийн нийт монгол үгийн сангийн бүрэлдэхүүнийг гаргаж, орос орчуулгыг хадах ажлыг монголын тал дангаар гүйцэтгэх, толь бичгийн нарийн боловсруулалт хийх ажлыг хоёр тал хамтран гүйцэтгэхээр тохиров.

Энэ хугацаанд хоёр талын ажлын хэсэг монгол толгой үгийн цэсийг хянаж, байхгүй үгийг нэмэх, хэрэгцээгүй үгийг хасах, толгой үгийн салбар утгууд, тэдгээрийн дэс дарааг хянах, утга тодруулах жишээ тэдгээрийн орчуулга, найруулгын зөв эсэхийг шалгах, орчуулгын үсгийн дүрмийн болон өргөлтийн алдааг

хянах, орчуулгын найруулгын тохироог хянах, монгол хэвшмэл хэллэгийн үгчилсэн ба утга зохиолын орчуулгыг шалгаж, бололцоотой газар утга, найруулгын талаар дүйх орос хэвшмэл хэллэг олж тавих, адил бичлэгтэй үгсийг тус тусад нь толгой үг болгох, олон хувилбартай бичлэгтэй үгсийн бичгийн хэлний хэлбэрийг гол болгон баримтлах, үгсийн гарал, харь хэлний үгсийн эх дуудлага, монгол хэлэнд заншсан дуудлага зэрэг нарийн асуудлыг аль болох зөв шийдэх зэргээр толь зүйн нарийн боловсруулалт хийсэн болно. Жишээ нь:

АДАГ III буруу хэлбэрж. губа“ч-медве“дь; өтөг — *ийг* үз.

Бид монгол орос дэлгэрэнгүй их толийг чухам дээр дурдсан 1957 оны 22 мянган үгтэй жижиг толинд суурилан улмаар Монголын ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн картын санд хадгалагдаж буй монгол үгийг бүртгэсэн 2,5 сая орчим картын хэрэглэгдэхүүнээр баяжуулан боловсруулсан болно. Үүнээс гадна урьд өмнө хэвлэгдэн гарсан том жижиг янз бүрийн толь, хуучин шинэ нэр томъёоны янз бүрийн толь, орчуулгын зохиол, тухайлбал, улс төр, эдийн засгийн ухаантай холбогдолтой зохиол, уран зохиол, орчин үед хэвлэгдэн гарч байгаа тогтмол хэвлэл, сонин сэтгүүлийг ашигласан болно.

Монгол орос дэлгэрэнгүй их толь нь хоёр хэлний орчуулгын төдийгүй үгийн гарлын, тайлбар болон нэвтэрхий толийн чанартай бөгөөд шинэ монголын утга зохиолын хэлний түүхэн хөгжлийн гуравдугаар шат буюу XVII зуунаас эдүүгээ хүртлэх үеийн үгсийн баялаг санг аль болохуйц багтаасан 70 мянган толгой үг бүхий сая гаруй үг хэллэгийн гол болон салаа утгыг дэлгэрэнгүй гаргаж хэлц үг, зүйр цэцэн үгээр баяжуулсан болно.

Энэ толинд үгсийн сан, хэлзүйн харилцааг үнэн зөв тусгаж, уг толийг урьдын толь зүйчдийн алдаанаас ангижруулан, хэлний толь нэртэй үгийн толь биш, өгүүлэхийн толь болгох, үүнд, жишээлбэл, нэр үгийн -н тэй, -н-гүй хоёр үндсийн ялгаа, хэлзүйн хөгжилдөө үгсийн аймгийн өөр өөр айн үүргийг давхар гүйцэтгэх буюу **очих- ч, орхих- чих** гэх мэтийн залгавар болон хувирсан үгсийг орчин үеийн үгсийн санд эзэлж байгаа жинхэнэ байдалаар нь үзүүлэхийг эрмэлзэв. Жишээ нь:

САР сар-а ме“сяц (*единица исчисления времени, равная одной*

двенадцатой части года); **сарын эх** нача“ло ме“сяца; **нэгдүгээр сар** янва“рь...

САР(АН) *саран* 1) луна“; ме“сяц; **саран гэрэл** сия“ние луны“; 2) лы“сина (*напр. у лошади*)...

ОД(ОН) *одон* 1) звезда“...; 2) кру“глые пя“тнышки, звёздочки на материя“ле (*напр. на шёлке*)...

ОДОН(Г) *одон* о“рден...

Хоёр үндэст үгийн -н-тэй үндэс үйлдэхийн тийн ялгалаар ялгагдах ахул, түүнийг салбар утга болгон бичсэн болно. Жишээлбэл:

АДУУ(Н) *адугу* 1. 1) табу“н, кося“к лошаде“й; ко“нское ста“до; ... 2) ло“шадь, ло“шади, ко“ни; ... 3) **адуунаар** в табуне“; 4) *тодотголын үүргээр*: ко“нный; ко“нский; конево“дческий; 2. ко“нный; ко“нский...

Язгуураасаа хэлний угийн -н-ээр төгсдөг нэр үгийн ард халт дотор (г) гэж бичсэн болно. Жишээлбэл:

САН(Г) *санг* казна“...

СОЁОЛОН(Г) *пятиле*“тний (*о домашних животных*).

1940-оод оноос хойш монголын нийгэм улс төрийн амьдралд асар их өөрчлөлт гарсан нь юуны өмнө монгол хэлний үгсийн сангийн хөгжилд шууд нөлөөлсөн болно.

Уул толийн бүрэлдэхүүнд Монголын ард түмний аж байдал, эдийн засаг, нийгэм улс төр, соёлын амьдралтай зайлшгүй холбоотой үгс, нийгэм улс төр, шинжлэх ухаан техникийн зарим нэр томъёо, нүүдлийн мал аж ахуйтай манай монголчуудын амьдралын өвөрмөц байдлыг харгалзан бэлчээрийн ургамал, хөдөө аж ахуйн нэр томъёог нэлээд өргөн оруулсан болно. Мөн манай орны хөгжлийн хэрэгцээний шаардлагаар гарч байгаа шинэ үг хэллэг, түүхийн ном судар, хуучин уран зохиол уншин ойлгоход эрхбиш мэдвэл зохих хуучирсан үгс, эртний хуучин үгс, зарим нэг этгээд үг, бүдүүлэг үгсийг зохих хэмжээгээр оруулав. Ингэснээрээ энэ толийн эрдэм шинжилгээний ач холбогдол алдагдах биш харин ч орчин үеийн практик хэрэгцээг хангах, олны анхаарал сонирхол татах толь болж үлдэх юм. Жишээ нь:

АЯГА IV: аяга тахимлаг *уйг.*, *хорш.* ни“щенствующий мона“х (*достойный почтения — титул монахов*).

БИЙБАА бийваа — 2 үз., шүр сувдан дэлнээс нь бийбаа ятгын дуу гараад... *аман. зох.* от развева“вшихся (кора“лловых и жемчу“жных) ко“нских воло“с пе“ние скри“пок и гусле“й не-сло“сь...

Сүүлийн үед харь хэлнээс монгол хэлэнд орж ирсэн түгээмэл дэлгэрсэн үгийг оруулав. Үгсийн гарал, харь хэлний үгийн эх дуудлага, монгол хэлэнд заншсан дуудлагад нэлээд анхаарал тавив. Жишээ нь:

АРШААН рашаан — 2 үз.

РАШААН *са.* арша“н, целе“бный минера“льный исто“чник.

Монгол орос дэлгэрэнгүй их толийн зохиогчид монгол толгой үгсийн бүрэлдэхүүнийг гаргаж, толийн өгүүллэлийг боловсруулах, орос орчуулгыг хадах ажлыг гүйцэтгэж, уг орчуулгыг хянах, найруулан засах, толийн бүтцийг сайжруулан чанаржуулах, толь бичгийн боловсруулалт хийх, хянан найруулах ажлыг хамтран дуусгалаа. Зохиогчдын хамтарсан хэсгийг шинжлэх ухааны үүднээс зохион байгуулалттайгаар удирдаж, түүнийг санхүүжүүлэх, материал, техникээр хангах ажлыг Оросын ШУА-ийн Хэлшинжлэлийн хүрээлэн нэр төртэй даалаа.

Монгол орос дэлгэрэнгүй их толийг бүтээхэд монгол хэлний томоохон эрдэмтэн академич А.Лувсандэндэв (1927-1997) асар их хувь нэмэр оруулсныг дурдая. Тэрээр цаг бусаар таалал төгсөх хүртлээ зохиогчдын хэсгийг ахалж, толийн ерөнхий редакторын үүргийг гүйцэтгэж байв.

Толийн үлдсэн хэрэглэгдэхүүнийг бүхэлд нь редакторлах хариуцлагатай үүргийг хэл бичгийн ухааны доктор, профессор Ц.Цэдэндамба (1940-2001), Оросын ШУА-ийн Хэлшинжлэлийн хүрээлэнгийн урал-алтай хэлний хэлтсийн монгол хэлний хэсгийн эрхлэгч, хэл бичгийн ухааны доктор, профессор Г.Ц. Пюрбеев нар гүйцэтгэв.

Толийн зохиогчид эрдэм шинжилгээний ажилтан Ё. Баярсайхан, Г. Гантогтох, Д. Дорж, Г. Мижиддорж, Б. Сумъяабатар, О. Сүхбаатар, А.А. Дарбеева, Г.Ц. Пюрбеев, З.В. Шевернина (1927-2002) нар ихээхэн хувь нэмэр оруулсан болно.

Эрдэм шинжилгээний ажилтан Г.Мижиддорж 1984 онд цаг бусаар таалал төгсөх хүртлээ толийн 1, 2-р ботийн ихэнх толгой үсгийг зохиож жинтэй хувь нэмэр оруулсныг онцлон тэм-

дэглэе.

Мөн толийн хэрэглэгдэхүүнийг хянан зассан Г.Ц. Пюрбеев, М.Е. Алексеев, Academia хэвлэлийн газрын редактор В.А. Попов, О.Г. Юрин нарт онцгой талархаж байна.

Энэхүү бүтээлийн бэлтгэх ажлыг ивээн тэтгэсэн болон хэвлүүлэхэд санхүүгийн туслалцаа үзүүлсэн Орос Улсын Хүмүүнлэгийн Ухааны Сан (РГНФ), түүний ажилтнуудад талархал илэрхийлье.

Энэхүү толь нь монгол хэл судалж буй гадаадын хүмүүст болон монгол хэлээр орчин цагийн хэвлэл унших, монголоос орос хэлнээ ном зохиол орчуулах, улмаар монгол орос хэлээр улбаалан гадаад хэл сурах янз бүрийн ажил мэргэжлийн хүмүүст зориулагдсан өргөн олон түмний эрэлт хэрэгцээг хангах монголын утга зохиолын хэлний эрдэм шинжилгээ-практик ач холбогдолтой гарын авлага, лавлах бичиг болох юм. Тэрчлэн хоёр улсын болон гадаад орны их дээд сургуулийн хэл бичгийн ангид монгол хэл заах, сурахад эрдэм шинжилгээ-сургалтын гарын авлага болно.

Уг толь нь хэл шинжээч, утга зохиол судлаач, аман зохиол судлаач, угсаатны зүйн судлаач зэрэг монголын судлалын бусад салбарын мэргэжилтэн нарын судалгааны сонирхолд бүрэн нийцнэ.

Мөн тэрчлэн зөвхөн монгол хэл судлаач нарт төдийгүй түрэг судлаач, тунгус манж хэлний мэргэжилтэн болон улмаар алтай хэлний мэргэжилтэн нарын судалгааны сонирхолд бүрэн нийцэх бөгөөд монгол хэлний шинжлэлд болон дэлхийн хэлшинжлэлд зохих байр сууриа эзлэх томоохон хэмжээний шинэ бүтээл болсныг тэмдэглэе.